



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/222

Булган сум

Ой, ойн санд аж ахуйн үйл ажиллагаа
явуулахыг түр хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам”, Улсын онцгой комиссын даргын, 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түймрийн аюултай үед ой, ойн сан бүхий газарт аялах, ан агнах, Бугын эвэр түүх, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2026 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэл тус тус хориглосугай.

2.Дээрх хугацаанд түймрийн аюулын зэрэглэл, I-II зэрэглэлд хүрч буурсан үед, хуулийн этгээд ойн тухай хуульд заасан ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, мод бэлтгэл, ойн арчилгаа, цэвэрлэгээний үед түймрийн аюулгүй байдлыг хангахад тавигдах тусгай шаардлагыг хангаж, орон нутгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу ой, ойн сангаас мод бэлтгэх үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсүгэй.

3.Түймрийн аюултай үед сумын Шуурхай штабын үйл ажиллагааг идэвхжүүлж, аймгийн Шуурхай штаб, Онцгой байдлын газар, Байгаль орчны газрыг тогтмол мэдээллээр хангаж ажиллахыг сум болон сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4.Түймрийн аюулын ангилал, зэрэглэлийг өдөр бүр гаргаж, Онцгой байдлын газар, Байгаль орчны газар, сумдын Засаг даргын тамгын газарт мэдээлж ажиллахыг Ус цаг уур, орчны шинжилгээний төв (Б.Нандинбат)-д үүрэг болгосугай.

6326010294

5.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Н.Хишигдорж), Байгаль орчны газар (А.Гантөмөр), сум болон сум дундын Ойн анги, сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР

